



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026.01.09

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Монголын төмөр зам” /МТЗ/ ТӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

“МТЗ” ТӨХК-ийн 2025 үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 72.6%-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
4	-	-	4	-	30.0%

2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	

5	-	-	5	-	30.0%
---	---	---	---	---	-------

2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
56	43	12	1	-	88.9%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
16	13	2	-	1	-	93.3

2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
32	26	4	-	1	1	93.3%

2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
2	2	-	-	-	-	100%

2.7. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	95.8
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	88.1
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	98.4
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	90.3
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	89.3
Дүн		93.7

2.8. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

	Үүнээс:	
--	---------	--

Мэдээлэл оруулах тоо	Мэдээлэл оруулсан тоо	Хугацаандаа	Хоцорсон	Мэдээлээгүй	Гүйцэтгэлийн хувь
180	180	180	-	-	100.0

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

“МТЗ” ТӨХК нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 56 арга хэмжээтэйгээр боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. Үүнээс 34 арга хэмжээг улирал бүрийн зорилтот түвшнийг тодорхойлоогүй бөгөөд энэ нь нийт арга хэмжээний 60.7 хувийг эзэлж байна. /1.4, 1.12-1.19, 1.23-1.32, 2.1 гэх мэт/

Хэрэгжилтийн байдал:

1) “МТЗ” ТӨХК-ийн 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт гэсэн 8 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 72.6%-тай байна.

2) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх ажил ТЭЗҮ-ийн төслийг холбогдох ажлын хэсэг, салбарын шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцэж дэмжсэн боловч төслийг цааш хэрэгжүүлэх шийдвэр гарч, дараагийн шатанд шилжүүлсэн тухай баримт бичиг бүрдээгүйгээс хэрэгжээгүй байна.

3) Шивээхүрэн–Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын төсөл нь 2025 онд судалгаа, зохион байгуулалт, хоёр талын зөвшилцлийн шатанд байсан бөгөөд барилгын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай шийдвэр, бэлтгэл ажил хийгдээгүй байна.

4) Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний түүхий эд (мидлинг)-ийг төлөвлөсөн хэмжээнд тээвэрлэх ажил, Монгол Улсын Засгийн газар болон “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо”-ны 2025 оны 01 дүгээр сарын хамтарсан хурлын шийдвэр, мөн “Тавантолгой түлш” ХХК-иас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/16, 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/223 дугаартай албан бичгүүдийн дагуу мидлинг тээвэрлэлтийг зогсоосонтой холбоотойгоор хэрэгжээгүй байна.

5) Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийн дагуу олон улсын тээвэрлэлтийг жигдрүүлэх арга хэмжээ нь бэлтгэл ажлын шатанд хэрэгжиж байгаа бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжихээр хойшлогдсон байна.

6) Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээрийг шинэчлэх төслийг БНХАУ-ын тал эцэслэн боловсруулж, Монгол Улсын талд ирүүлээгүй байна.

7) “МТЗ” ТӨХК-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 56 арга хэмжээний хэрэгжилт 87.3% байна. Үүнээс 76.8% нь хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн болон хүрэх шатандаа, 23.2% нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

8) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Төмөр замаар 11.5 сая.тн ачаа тээвэрлэнэ.	89.4
Зорилт 2. Төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.	Шивээхүрэн-сэхээ боомтын хил холболтын төмөр замыг байнгын ашиглалтад оруулна.	71.7
Зорилт 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.	Аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулсан байна. 599 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулна. 692 ажилтныг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангасан байна. 462 ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.	83.3
Зорилт 4. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангана.	ажилтнуудын үндсэн цалинг 10 хүртэлх хувиар нэмэгдүүлнэ.	100.0
Зорилт 5. Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Хүний нөөцийн мэдлэг чадавх, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр 20 сургалт зохион байгуулна. Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах хүрээнд 100 мэдээ, мэдээллийг нийтэлнэ.	100.0
Зорилт 6. Дотоод аудит, тээврийн хяналт шалгалт хийж, зөвлөмж, шаардлага өгөх замаар илэрсэн зөрчлийг арилгуулж, ажлыг сайжруулна.	Компанийн хэмжээнд дотоод аудитыг 9 удаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хяналт шалгалтыг 46 удаа тус тус зохион байгуулна.	98.7

9)Төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалсан. Үүнд: дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ буурсны улмаас биржээр нүүрс арилжаалагдаагүй, хүлээн авагч тал нүүрс худалдан авахаас түр хугацаанд татгалзсан, мөн Монгол Улсын Засгийн газар болон Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос мидлинг (баяжуулалтын завсрын бүтээгдэхүүн)-ийн тээврийг зогсоох шийдвэр гаргасан зэрэг нь нөлөөлсөн.

10) Тус байгууллагын 2025 оны II улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн 6 зөвлөмж өгсөн боловч Засгийн газрын 2025 оны “Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоол, Зам, тээврийн сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, мөн “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлэх арга хэмжээг авсан.

Дээрх зохион байгуулалтын өөрчлөлт, чиг үүрэг шилжилттэй холбогдуулан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан байна.

11) Яам, тээврийн яамнаас 2025 оны 10-11 сард яам болон харьяа байгууллагуудын “Хяналт шалгалт болон аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт-д дотоод аудит хийж, “МТЗ” ТӨХК-ийн хэрэгжилт 55.0 хувь буюу хангалтгүй үнэлэгдсэн байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас явуулсан хяналт, шалгалтын дүнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 86.0 хувьтай байгаа бөгөөд дээрх хоёр арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 53.6 хувь байна.

Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
	Нийт	Үүнээс		
		Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
ЗТЯ	11	6	-	55.0%
ЗГХХГ	17	9	-	86.0%
Нийт	28	15	-	53.6%

Энэ нь зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, хугацааг бодитой тооцоолоогүй, хариуцах эзэн нь тодорхой бус төлөвлөсөн, хэрэгжилтийг баримтад суурилан тайлагнаагүй, нотлох баримтыг хавсарган ирүүлээгүй зэргээс шалтгаалсан байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 30-59 хувийн хэрэгжилттэй 4, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 30-59 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээний биелэлтийг зорилтот түвшинд хүргэн ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг улирал тутам шинэчлэн ирүүлэх;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:
Үүнд:

- Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах болон эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй ажилтнуудын амь, нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлын хүрээнд үр дүнтэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

- Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ТЗХАБ)-ын Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр (ОУАХХ)-ийн нөхцөлөөр олон улсын тээвэрлэлтийг эхлүүлж, жигдрүүлэх,

- Зүтгүүрийн ашиглалт болон засварын зааврын орчуулгыг яаралтай батлуулах;

- Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 384км төмөр замын төслийг эхлүүлэх ажлын хүрээнд ТЭЗҮ-ийг ЗТЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлэх;

- Монголын төмөр зам” ТӨХК-ийн төв оффисыг орон нутагт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахад холбогдох судалгаа, тооцооллыг гаргаж Зам, тээврийн яаманд танилцуулах;



3. “Монголиан порт групп” ХХК-ийн ТУЗ-ийн даргыг томилж, үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө, тайлан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон Зам, тээврийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрэмд нийцүүлэн алдаагүй ирүүлж хэвших;

5. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан, уг төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд нотлох баримт, материалын хамт бүрэн тайлагнадаг тогтолцоог хэвшүүлэх;

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**“МТЗ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**
(жилийн эцсийн байдлаар)

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	4	4	30.0	20
2	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	5	5	30.0	20
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	56	56	88.9	20
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	16	15	93.3	20
5	Сайдын тушаалын хэрэгжилт	32	30	93.3	10
6	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	2	2	100.0	10
7	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	58	58	93.7	10
8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	180	180	100.0	10
Нийт		353	350	72.6	